

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2024 оны ... дугаар
сарын . . .-ны өдөр

Дугаар.....

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 36 дугаар зүйлийн 36.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх, мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журмыг хавсралтаар баталсугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг хүүхэд хамгааллын байгууллагын үйл ажиллагааны жил бүрийн төсөвт тусгаж, хэрэгжүүлж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2024 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар
тушаалын хавсралт

ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН НИЙГМИЙН АЖИЛТАНД НИЙГМИЙН АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ЯВУУЛАХ ЭРХ, МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх, мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох харилцааг Хүүхэд хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, энэ журмаар зохицуулна.

1.2.Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх, мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааны зорилго нь нийгмийн ажилтны мэргэшил, ур чадварын өсөлтийг дэмжих, тасралтгүй хөгжүүлэх, нийгмийн ажил, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэнэ.

1.3.Хүүхэд хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/, энэ журамд заасны дагуу нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх авсан хүнийг хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнаар ажиллуулна.

1.4.Мэргэшлийн зэрэг нь хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан газар, сум, хороо /цаашид “хүүхэд, гэр бүлийн байгууллага” гэх/-д ажиллаж байгаа хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан /цаашид “нийгмийн ажилтан” гэх/-д хамаарна.

Хоёр.Нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх олгох

2.1.Хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Хүүхэд хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 36 дугаар зүйлийн 36.1-д заасан шаардлагыг хангасан хүнд нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх олгоно.

2.2.Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангасан талаарх баримт бичгийг бүрдүүлэн ажилтанд нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх олгуулах саналыг Хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хандаж шийдвэрлүүлнэ.

2.3.Нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх авсан хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд хувийн дугаар бүхий албаны үнэмлэх олгоно.

Гурав.Нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх түдгэлзүүлэх,

хүчингүй болгох

3.1. Дараах тохиолдолд нийгмийн ажилтны үйлчилгээ явуулах эрхийг түдгэлзүүлнэ:

3.1.1. нийгмийн ажилтан хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаанд;

3.1.2. хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага хооронд, эсхүл байгууллага дотроо албан тушаалын тодорхойлолтод зааснаар нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх шаардлагагүй албан тушаалд сэлгэн болон шилжин ажиллаж байх хугацаанд.

3.2. Энэ журмын 3.1-д заасан хугацаа дуусаж, албан тушаалын тодорхойлолтод зааснаар нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх шаардлагатай албан тушаалд томилогдсон нийгмийн ажилтанд эрхийг сэргээн олгоно.

3.3. Дараах тохиолдолд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх эрхийг хүчингүй болгоно:

3.3.1. Төрийн албаны тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомж зөрчсөн;

3.3.2. төрийн захиргааны албан хаагчийн болон Хүүхэд хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д заасан үүргээ биелүүлээгүй, хориглох зүйл, ажилтны ёс зүйн хэм хэмжээг ноцтой буюу удаа дараа зөрчсөн, эсхүл мэргэжлийн алдаа гаргасан;

3.3.3. албан тушаалын тодорхойлолтод заасан албан үүргээ удаа дараа хангалтгүй биелүүлсэн, хуулиар олгосон эрхийг хэтрүүлсэн;

3.3.4. гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

3.3.5. ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан;

3.3.6. тэтгэвэрт гарсан, өөр байгууллагад шилжин ажилласан;

3.3.7. нас барсан.

3.4. Энэ журмын 3.1-3.3-т заасан үндэслэлээр эрх түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох саналыг хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тавьж шийдвэрлүүлнэ.

3.5. Энэ журмын 3.1, 3.3-т зааснаар эрхийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон ажилтны үнэмлэхийг харьяалах газар болон аймаг, нийслэл, дүүргийн хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллагын дарга акт үйлдэн хураан авна.

3.6. Эрх нь түдгэлзсэн, хүчингүй болсон нийгмийн ажилтны үнэмлэхийг хурааж аваагүй тохиолдолд тухайн нийгмийн ажилтны харьяалах байгууллагын даргаар үнэмлэхний үнийг гурав дахин нэмэгдүүлэн төлүүлнэ.

Дөрөв. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд мэргэшлийн зэрэг олгох

4.1.Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны мэргэшлийн зэргийг хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр олгож, түдгэлзүүлнэ.

4.2.Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд “Ахлах”, “Тэргүүлэх”, “Зөвлөх” гэсэн мэргэшлийн зэрэг олгоно. Мэргэшлийн зэргийг давхардуулан болон алгасаж олгохгүй.

4.3.Нийгмийн ажилтанд мэргэшлийн зэрэг олгоход дараах нийтлэг шалгуур үзүүлэлтийг харгалзана:

4.3.1.Нийгмийн ажлын мэргэжилтэй, эсхүл боловсрол, нийгмийн ухааны чиглэлээр дээд боловсрол эзэмшиж, нийгмийн ажлаар мэргэшүүлэх сургалтад хамрагдсан, нийгмийн ажилтнаар ажилласан туршлагатай байх;

4.3.2.Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэргэшсэн байх;

4.3.3.Ёс зүйн хэм хэмжээг сахин холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажилладаг байх.

4.4.Ахлах мэргэшлийн зэргийг доор дурдсан шалгуур хангасан нийгмийн ажилтанд олгоно:

4.4.1.нийгмийн ажилтнаар 4-өөс доошгүй жил ажилласан байх;

4.4.2.хүүхэд, гэр бүлийн хөгжил, хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр сүүлийн хоёр жилийн хугацаанд мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, 2 багц цагийг тооцуулсан байх;

4.4.3.хууль тогтоомж, стандарт, дүрэм журмыг бүрэн судалж, үйл ажиллагаандаа мөрдөж, ажлын гүйцэтгэл нь сүүлийн 2 жил хангалттай сайн үнэлгээтэй байх;

4.4.4.нийгмийн ажлын мэргэжлийн удирдлагаар хангах сургалтад хамрагдаж, мэргэжлийн удирдлагаар хангах мэдлэг, чадвартай болсон байх;

4.4.5.сүүлийн 1 жил ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй, сахилгын шийтгэлгүй байх.

4.5.Тэргүүлэх мэргэшлийн зэргийг доор дурдсан шалгуур хангасан нийгмийн ажилтанд олгоно:

4.5.1.энэ журмын 4.4-т заасан мэргэшлийн зэрэг хүчинтэй байх;

4.5.2.хүүхэд, гэр бүлийн хөгжил, хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр сүүлийн хоёр жилийн хугацаанд мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, 3 багц цагийг тооцуулсан байх;

4.5.3.нийгмийн ажилтнаар 8-аас доошгүй жил ажилласан байх;

4.5.4.хууль тогтоомж, стандарт, дүрэм журмыг бүрэн судалж, үйл ажиллагаандаа мөрдөж, ажлын гүйцэтгэл нь сүүлийн 2 жил хангалттай үнэлэгдсэн;

4.5.5.Нийгмийн ажилтныг хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлагаар хангах ур чадвар, туршлагатай, 4-аас доошгүй ахлах нийгмийн ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангасан туршлагатай байх;

4.5.6.нийгмийн ажилтны мэргэшлийн зэрэг олгох шалгалт өгч тэнцсэн байх;

4.5.7.сүүлийн 1 жил ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй, сахилгын шийтгэлгүй байх.

4.6.Зөвлөх мэргэшлийн зэргийг доор дурдсан шалгуур хангасан нийгмийн ажилтанд олгоно:

4.6.1.энэ журмын 4.5-д заасан мэргэшлийн зэрэг хүчинтэй байх;

4.6.2.хүүхэд, гэр бүлийн хөгжил, хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;

4.6.3.хүүхэд, гэр бүлийн хөгжил, хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр сүүлийн хоёр жилийн хугацаанд мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, 4 багц цагийг тооцуулсан байх;

4.6.3.нийгмийн ажилтнаар 12-аас доошгүй жил ажилласан байх;

4.6.4.хууль тогтоомж, стандарт, дүрэм журмыг бүрэн судалж, үйл ажиллагаандаа мөрдөж, ажлын гүйцэтгэл нь сүүлийн 2 жил хангалттай үнэлэгдсэн;

4.5.5.Тэргүүлэх зэрэгтэй нийгмийн ажилтныг хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлагаар хангах ур чадвартай, 3-аас доошгүй тэргүүлэх нийгмийн ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангасан туршлагатай байх;

4.5.6.нийгмийн ажилтны мэргэшлийн зэрэг олгох шалгалт өгч тэнцсэн байх;

4.6.7.сүүлийн 1 жил ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй, сахилгын шийтгэлгүй байх.

4.7. Тэргүүлэх зэрэгтэй нийгмийн ажилтан нь тухайн мэргэжил, мэргэшлийн чиглэлээрх нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан, бүс, орон нутгийн нийгмийн ажилтанд зөвлөх, тэдний хөгжилд хувь нэмэр оруулах ур чадвартай байна.

4.8.Зөвлөх зэрэгтэй нийгмийн ажилтан нь тухайн мэргэжил, мэргэшлийн чиглэлээрх нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан, салбар, үндэсний түвшинд бусад нийгмийн ажилтанд зөвлөх, тэдний хөгжилд хувь нэмэр оруулах ур чадвартай манлайлагч байна.

Тав.Мэргэшлийн зэрэг олгох, түдгэлзүүлэх

5.1.Аймаг, нийслэл, дүүргийн хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага нь нийгмийн ажилтанд “ахлах” мэргэшлийн зэрэг олгох санал, “тэргүүлэх” болон “зөвлөх” зэргийн шалгалтад оролцох шаардлага хангасан нийгмийн ажилтны судалгааг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад цахимаар ирүүлэх бөгөөд дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

5.1.1.энэ журмын 4.3-4.6-д заасан шалгуур үзүүлэлтийг хангасныг нотлох баримт бичиг;

5.1.2.хамт олны бичгээр гаргасан санал.

5.2.Мэргэшлийн зэрэг олгох, сунгах шалгалтыг гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар байгуулсан ажлын хэсэг (цаашид “Шалгалтын комисс” гэх) зохион байгуулна.

5.3.Шалгалтын комисс шалгалтыг шударга, ил тод, эрх тэгш байх зарчим баримтлан холбогдох хууль тогтоомж, батлагдсан шалгалтын журмын дагуу жил бүрийн 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулна.

5.4.Шалгалтыг программ хангамж, техник, тоног төхөөрөмж, аюулгүй, найдвартай сүлжээ бүхий Төрийн албаны төв байгууллага, төрийн болон төрийн бус бусад байгууллагатай хамтран зохион байгуулж болно.

5.5.Шалгалтын комисс нь шалгалтын бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулах, шалгалтад тэнцсэн нийгмийн ажилтанд “тэргүүлэх” болон “зөвлөх” мэргэшлийн зэрэг олгох, сунгах, шалгалтад тэнцээгүй нийгмийн ажилтны мэргэшлийн зэргийг цуцлах санал гаргах ажлыг хариуцан ажиллана.

5.6.Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллагад 15 ба түүнээс жил ажилласан нийгмийн ажилтан энэ журамд заасан болон доор дурдсан нөхцөл, шалгуурыг хангасан бол түүнд мэргэшлийн зэргийг шалгалтгүйгээр олгож, сунгаж болно. Үүнд:

5.6.1.мэргэшлийн зэргийн шалгалтад 3 удаа тэнцсэн 45 ба түүнээс дээш настай;

5.6.2.шалгалтын тов зарлахаас өмнө эмэгтэй 52, эрэгтэй 57 насанд хүрсэн;

5.6.3.Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаалал, нийгмийн ажлын чиглэлээр докторын зэрэгтэй.

5.7.Нийгмийн даатгалын байцаагч, ажилтан хүндэтгэн үзэх шалтгаанаар зөвхөн нэг удаа шалгалтаас чөлөөлөгдөнө.

5.8.Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мэргэшлийн зэрэг олгох, сунгах, хүчингүй болгох нийгмийн ажилтны баримт бичгийг шалгаж нэгтгэн, саналын хамт хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.

5.9.Мэргэшлийн зэрэг олгох эсэх асуудлыг хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор шийдвэрлэнэ.

5.10.Энэ журмын 4.3-4.6-т заасан шалгуур үзүүлэлтийг хангасан нийгмийн ажилтанд шат дараалан мэргэшлийн зэргийг 4 жилийн хугацаатай олгоно. Мэргэшлийн зэргийг шат дараалан олгох доод хугацаа 1 жил байна.

5.11.Мэргэшлийн зэргийг дараах тохиолдолд түдгэлзүүлнэ. Үүнд:

5.11.1.албан хаагч төрийн албанаас түр чөлөөлөгдсөн бол ажилдаа эргэн орох хүртэл;

5.11.2.хүүхэд асрах чөлөөтэй байгаа хугацаанд.

5.12.Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага хооронд шилжин эсхүл сэлгэн ажиллах хугацаанд тухайн албан хаагчийн мэргэшлийн зэрэг хэвээр хадгалагдана.

5.13.Нийгмийн ажилтан нь төрийн албанаас чөлөөлөгдсөн, халагдсан, нас барсан, ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргасан, “ахлах” болон “зөвлөх” зэрэгтэй

нийгмийн ажилтан нь зэрэг сунгах шалгалтад тэнцээгүй, зэргийн хугацаа сунгах шалгалтад хамрагдаагүй, ёс зүйн болон сахилгын шийтгэл хүлээсэн бол мэргэшлийн зэргийг тухай бүр хүчингүй болгоно.

5.14.Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мэргэшлийн зэргийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай саналыг тухай бүр хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тавьж шийдвэрлүүлнэ.

Зургаа.Мэргэшлийн зэргийн нэмэгдэл

6.1.Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллагад хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны эрхтэйгээр нийгмийн ажилтнаар ажиллаж байгаа хугацаанд олгоно.

6.2.“Зөвлөх” мэргэшлийн зэрэгтэй нийгмийн ажилтанд 20 хувийн, “Тэргүүлэх” мэргэшлийн зэрэгтэй нийгмийн ажилтанд 15 хувийн, “Ахлах” мэргэшлийн зэрэгтэй нийгмийн ажилтанд 10 хувийн нэмэгдлийг албан тушаалын үндсэн цалингаас тооцож сар бүр олгоно.

6.3.Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллагын үйл ажиллагааны жил бүрийн төсөвт тусгаж батлуулна.

Долоо.Бусад зүйл

7.1.Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх, мэргэшлийн зэрэгтэй хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны талаарх хүний нөөцийн мэдээллийн санг бүрдүүлнэ.

7.2.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.